

МОНГОЛ, МАНЖ ХЭЛНИЙ ЗАРИМ ЦАГААР ТӨГСГӨХ НӨХЦӨЛИЙН ТУХАЙД

Э.Мөнхцэцэг*

Товч агуулга: манж, монгол хэлний үйлийн төгсгөх нөхцөл, тэдгээрийн утгыг Чингийн үеийн толь бичгийн дурсгалуудаас тодруулах боломжтой юм. Энэхүү өгүүлэлд 1717 онд найруулан бичсэн «Хааны бичсэн манж, монгол үгний толь бичиг»-ийг судлагдахуун болгон авч, түүнд агуулагдаж буй мэдээлэлд түшиглэн монгол, манж хэлний цагаар төгсгөх нөхцөлийн онцлог шинжийг илрүүлэхийг оролдлоо.

Түлхүүр үг: толь бичиг, толгой үг, тайлбар, үйл үг, үйлийн төгсгөх нөхцөл, утга

1717 онд Манжийн Энх-Амгалан хааны зарлиг, ивээл дор Бээжинд бар сийлэн тархаагдсан «Хааны бичсэн манж, монгол үгний толь бичиг» (ма. *Han-i araha manju monggo gisun-i buleku bithe*, мо. *Qayan-u bičigsen manju, mongyol ügen-ü toli bičig*) (цаашид НАММ гэх) нь манж толь бичгүүдийн дотор голлох байрыг эзлэх бөгөөд **манж, монгол хэлийг** харьцуулан судлахад чухал ач холбогдолтойд тооцогддог. Тус толийг манж хэлний зүйл хуваасан тайлбар толь бичигт (1708) тулгуурлан зохиосон. Ингэхдээ бага зэрэг өөрчлөлт оруулж, монгол хэлнээ орчуулан эмхэтгэжээ.

НАММ тольд орсон бүх үг тайлбартай. Тэдгээр тайлбарт хэл зүйн янз бүрийн мэдээлэл агуулагддаг. Энэ нь уг тольд орсон үйлийн нөхцөл авсан үйл үгс, тэдгээр нөхцөлийн утгыг нарийвчлан шинжлэх боломжоор хангаж байгаа юм.

Энэхүү өгүүлэлд тус тольд орсон төгсгөх нөхцөл бүхий үйл үг, тэдгээрийн илтгэж буй утгыг авч үзэх болно.

* ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Харьцуулсан хэл шинжлэлийн салбарын эрхлэгч, доктор (Ph.D), дэд профессор. munkhtsetsege@mas.ac.mn

Манж хэлний үйл үгийг олон янзын нөхцөлөөр хувилгадаг. Тооны хувьд монгол хэлнийхээс цөөн бөгөөд олон утга илтгэдэг хэлбэр цөөнгүй байна (МХС, 2022). Энэ хоёр хэлэн дэх үйлийн нөхцөлийг өгүүлбэрт гүйцэтгэх үүргээр нь холбох нөхцөл, төгсгөх нөхцөл гэж хоёр хуваана. Төгсгөх нөхцөл нь өгүүлбэрийн төгсгөлд тохиолдож, өгүүлбэрт өгүүлэхүүн гишүүн болно. Төгсгөх хэлбэрт захиран хүсэх болоод цаг заах нөхцөлүүд хамаарна.

НАММ тольд төгсгөх нөхцөл авсан үйл үгийг их хэмжээгээр толилуулсан байна. Тэдгээр нь ихэвчлэн толийн үйл үгээр нэрлэгдсэн зүйлүүдэд байрлаж, өнгөрсөн, эсвэл одоо цагаар төгсгөх нөхцөлийн аль нэгээр хэлбэржжээ.

Өнгөрсөн цагаар төгсгөх нөхцөл: ма. $-ha^3$, $-ka^3$, мо. $-ba^2$ (PERF.PART)

Манж хэлэнд $-ha^3$, $-ka^3$ нөхцөлийг залгаж өнгөрсөн цагаар төгсгөх үйл үгийг үүсгэнэ. Энэ нөхцөл нь хэлбэрээрээ өнгөрсөн цагийн үйлт нэртэй тохирдог боловч нэр үг, үйл үгийг ардаа авдаггүй, ө.х. төгсгөлийн өгүүлэхүүний үүрэг гүйцэтгэдгээрээ үйлт нэрээс ялгаатай.

О.П. Суникийн тэмдэглэснээр «цөөн тооны үгэнд $-ka$ ($-ka \sim ko$), ихэнх үйл үг $-xa$ ($-xэ \sim xo$) хэлбэрийг авна. $-ka$ хэлбэрийг $-xa$ хэлбэрээр сольж хэрэглэх боломжтой ч, ховор тохиолддог. Үүний шалтгаан нь n - ээр төгссөн үйл үндсийн дараах $-ka$ хэлбэр хадгалагддагтай холбоотой юм. Өөр бусад тохиолдолд эгшгээр төгссөн үйл үндэст $-xa$ ($-xэ \sim xo$) хэлбэрийг залгана» гэжээ (Суник, 1962: 229).

Энэхүү $-ha^3$, $-ka^3$ нөхцөлийг монгол хэлэнд буулгахдаа өгүүлбэрийн төгсгөлд $-ba^2$ нөхцөлтэй утга дүйлгэн орчуулдаг. $-ba^2$ нөхцөл нь монгол бичгийн хэлэнд хэрэглэгдэж, мэдэгдэж хэдийнээ өнгөрсөн үйл хөдлөлийг (Rita Kullmann; Tserenpil, 1996: 186) илтгэнэ. Орчин цагийн монгол хэлний хэлбэр нь $-в$ болно.

НАММ толийн баримтыг нягтлан үзэхэд ма. $-ha^3$, $-ka^3$, мо. $-ba^2$ нөхцөлөөр хэлбэржсэн үйл үг харьцангуй цөөн тохиолдож байв. Эдгээр үг нь ихэвчлэн зүйл дотор, ингэхдээ зүйлийн сэдэв, үйл үгийн утгаас хамаараад харилцан адилгүй тоо хэмжээтэй байгаа юм. Жишээ нь, «Суух зогсох зүйл»¹-д багтсан 22 үйл үгийн ганц нь ч өнгөрсөн цагаар төгсгөх нөхцөл аваагүй. «Зовлон бэлэвсрэлийн зүйл»²-д нийт 26 үйл үг орсноос «нас барах»-тай холбоотой 8 үйл үгэнд ма. *ergen yadaḥa*, мо. *amin ṡarba* ‘амь гарав’; ма. *akū oho*, мо. *iigei bolba* ‘үгүй болов’; ма. *bederehe*, мо. *egebe* ‘эгэв’; ма. *dubehe*, мо. *ečüs bolba* ‘эцэс болов’; ма. *ufaraha*, мо. *qočurba* ‘хоцров’; ма. *bucehe*, мо. *ükübe* ‘үхэв’; ма. *šekehe*, мо. *kösibe* ‘хөшив’; ма.

¹ ма. *tere ilire hacin*, мо. *sayuqu joysuqu jüil*

² ма. *jobolon sinagan-i hacin*, мо. *jobalang belbestürel-ün jüil*

bujaha, мо. *γangγadba* ‘гангадав’ (НАММ, 3: 26r-28r) хэмээн өнгөрсөн цагаар төгсгөх нөхцөлийг залгажээ.

Эдгээр болон бусад жишээг (1-6) харвал өнгөрсөн цагт болсон үйл хөдлөлийг илтгэж байна. Манж тайлбарт нь түүнтэй ижил нөхцөлөөр хэлбэржсэн утга ойролцоо үгсийг ашиглаж утгыг нь тодорхойлсон бол, монголоор орчуулахдаа *-γsan*² нөхцөлийг хэрэглэжээ. Жишээ нь:

- (1) ма. *gidaha*, мо. *daruba* ‘дарав’ (< ма. *gida*- ‘дар-, шах-’, мо. *daru*- ‘дар-’) (НАММ, 3: 118v)³
ма. *hülha be afame burulabuha be*, мо. *qulayai-yi bayildun buruγulayulusan-i* ‘хулгайг байлдан буруулуулсныг’ (YT)⁴;
- (2) ма. *samsiha*, мо. *sarniba* ‘сарнив’ (< ма. *samsi*- ‘сарни-, бутар-’, мо. *sarni*- ‘сарни-’) (НАММ, 3: 121r)
ма. *bata gidabufi duin ici genehe-be*, мо. *dayisun daruγdaγu dörben tesi oduγsan-i* ‘дайсан дарагдаж дөрвөн тийш одсныг’ (YT);
- (3) ма. *saha*, мо. *medebe* ‘мэдэв’ (< ма. *sa*- ‘мэд-’, мо. *mede*- ‘мэд-’) (НАММ, 7: 56r-v)
ма. *beye-i ulhihe-be*, мо. *bey-e-yin tuγulusan-i* ‘биеийн туулсныг’ (YT);
- (4) ма. *boloko*, мо. *ariγudba* ‘ариудав’ (< ма. *bolokon*- ‘ариун’, мо. *ariγud*- ‘арууд-’) (НАММ, 17: 49r)
ма. *yaya bihe jaka gemu wajiha be*, мо. *aliba aγsan yaγum-a čöm baraγsan-i* ‘аливаа агсан юм цөм барсныг’ (YT);
- (5) ма. *amariha*, мо. *qojimdaba* ‘хожимдов’ (< ма. *amari*- ‘хожимд-’, мо. *qojimda*- ‘хожимд-’) (НАММ, 7: 69v-70r)
ма. *isara yabure bade tutaha sitabuha niyalma-be*, мо. *quraqu yabuqu γaγar-tur qočuruγsan qojidaγsan kümün-i* ‘хурах явах газарт хоцорсон хожидсныг хүнийг’ (YT);
- (6) ма. *urehe*, мо. *qalasiraba* ‘халшрав’ (< ма. *ure*- ‘боловсор-, халшир-’, мо. *qalasira*- ‘халшир-’) (НАММ, 8: 73r-v)
ма. *mujilen akahai isehe-be*, мо. *sedkil qalsiraγsayar jalqaγsan-i* ‘сэтгэл халширсаар залхсныг’ (YT).

Зарим тохиолдолд дурдан буй нөхцөлийг авсан үйл үг жинхэнэ нэртэй холбогдож үйлийн эзний хийх боломжтой аль нэг үйл хийгдсэнийг илтгэж байна. Жишээ нь,

ма. *jui banjiha*, мо. *keiken törübe* ‘хүүхэн төрөв’ (НАММ, 8: 20v); ма. *beye isihiha*, мо. *bey-e könggejibe* ‘бие хөнгөжив’ (НАММ, 8: 21r); ма. *aga jelaha*, мо. *boruγan jaliraba* ‘бороо залирав’ (НАММ, 1: 16v); ма. *aga galaka*, мо. *boruγan arilba* ‘бороо арилав’ (НАММ, 1: 16v); ма. *silenggi wasika*, мо.

³ Хаалтад толийн товчилсон нэр болон дэвтэр, хуудасны дугаарыг тэмдэглэв.

⁴ Тайлбаруудад орсон толгой үг болон ‘хэмээмүй’ (ма. *sembi*, мо. *ketemüi*) гэсэн үгийн давталтыг хассан болно.

sigüderi bayuba ‘шүүдэр буув’ (HAMM, 1: 18v); ма. *edun dekdehe*, мо. *salkin degdebe* ‘салхи дэгдэв’ (HAMM, 1: 23v).

Өнгөрсөн цагаар төгсгөх нөхцөл: ма. *-habi*³, мо. *-juqui*² (*-ji* / *-jai*²), *-čiqui*² (*-či* / *-čai*²) (PERF.PART)

Манж хэлний *-habi*³ нөхцөлийг авсан үйл үгс нь төгс өнгөрсөн цагаар төгссөн утгыг илтгэх бөгөөд хоёр махбодын нийлцээс (*-habi*³ < *-ha*³ + *bi*) бүтдэг. Нэг нь өнгөрсөн цагийн нөхцөл *-ha*³, нөгөө нь *bi*- ‘байх’ гэсэн туслах үйл үг болно.

Энэ нөхцөл нь монгол бичгийн хэлний *-juqui*² (*-ji* / *-jai*²), *-čiqui*² (*-či* / *-čai*²) нөхцөлтэй утга дүйнэ. Эдгээрээс *-ji*, *-či* нь хэрэглэгдэх дүрэм, илтгэх утгын хувьд бусадтайгаа адил боловч, яриа, бичгийн хэлний аль алинд тохиолддоогоороо онцлог юм.

Энэ тухай эрдэмтэн Хүрэлбаатар «... монгол бичгийн хэлний өнгөрсөн цагийн нөхцөл < *-jai*, *-čai* > нөхцөлийг < *-ji*, *-či* > гэж бичдэг нь ярианы дуудлагатай илүү ойртуулж бичих гэсэн эрмэлзэл» (Kürelbayatur, 2021: 251) гэж тэмдэглэсэн байдаг. Үнэхээр ийм байсан нь HAMM толийн доорх жишээнүүдээс харахад илэрхий байгаа юм.

Тольд манж хэлний *-habi*³ нөхцөлийг авсан үйл үг цөөн бөгөөд тэдгээрийг монгол хэлэнд буулгахдаа зөвхөн *-ji*, *-či* хэлбэрийг ашиглажээ. Энэ нөхцөлийг авсан үгсийг тайлбарт ихэвчлэн одоо-ирээдүй цагийн ма. *-ra*³, мо. *-qu*² хэлбэртэй үйл үгийг хэрэглэж, дууссан үйл, заримдаа одоо цагт болж буй үйлийн үр дүнг илэрхийлжээ (жишээ 5, 6, 7). Бусад тайлбарт нь тэдгээртэй утга ойролцоо үгийг ма. *-ha*³, мо. *-γsan*² бүтээврээр хэлбэржүүлэн ашигласан байна. Жишээнүүдийг толилуулъя.

- (1) ма. *aituhabi*, мо. *tengküreji* ‘тэнхэрч’ (< ма. *aitu*- ‘тэнхэр-’, мо. *tengküre*- ‘тэнхэр-’) (HAMM, 13: 16r)
ма. *niyalma hūwaliyašafi ebsi oho, jai wasifi dasame cira sindaha*, мо. *kümün mayujiraju inaysi boluγsan, jiči bayuraju dakin čirai jasaraγsan* ‘хүн муужирч нааш болсон, жич буурч дахин царай засарсан’ (ҮТ);
- (2) ма. *ekiyehebi*, мо. *qoruji* ‘хорж’ (< ма. *ekiye*- ‘хор-, дут-’, мо. *qoru*- ‘хор-’) (HAMM, 16: 40v)
ма. *yaya jaka komso oho*, мо. *aliba yayum-a čögen boluγsan* ‘аливаа юм цөөн болсон’ (ҮТ);
- (3) ма. *honggonohobi*, мо. *qongγurčaylaji* ‘хонгорцоглож’ (< ма. *hongono*- ‘хонгод-’, мо. *qongγurčayla*- ‘хонгорцогло-’) (HAMM, 16: 57v)
ма. *etuku manafi farsi farsi hūwajafi lekde lakda tuheke*, мо. *qubčasu elejü keseg keseg qayaraju unjing sanjing unaysan* ‘хувцас элж хэсэг хэсэг хагарч унжин санжин унасан’ (ҮТ);
- (4) ма. *iktakabi*, мо. *čuylaraji* ‘цугларч’ (< ма. *ikta*- ‘цуглар-’, мо. *čuylara*-

- ‘цуглар-’) (HAMM, 2: 44v-45r)
 ма. *bayita umesi labdu oho*, мо. *kereg masi ülemji boluysan* ‘хэрэг маш үлэмж болсон’ (YT);
- (5) ма. *wanggiyanahabi*, мо. *tomuyuraĭ* ‘томуурч’ (< ма. *wanggiyana-* ‘томуур-’, мо. *tomuyura-* ‘томуур-’) (HAMM, 10: 72r-v)
 ма. *niyalma šahūrafi oforo sibume genggiyen niyaki eyere*, мо. *kümün jikegücejü qabar böglüren singgen nisun urusqu* ‘хүн жихүүцэж хамар бөглөрөн шингэн нус урсах’ (YT);
- (6) ма. *buktakabi*, мо. *sedegerdüĭ* ‘сэдрэгтэж’ (< ма. *bukta-* ‘муруй-, нугар-’, мо. *sedegerdü-* ‘сэдрэгт-’) (HAMM, 10: 79v)
 ма. *amgaha de meifen bukdabufi nimere*, мо. *untaysan-dur küjügün nuṣulaɣdaɣu ebedküi* ‘унтсанд хүзүү нугалагдаж өвдөх’ (YT);
- (7) ма. *uyašanahabi*, мо. *quyangtuĭ* ‘хуянтаж’ (< ма. *uyašana-* ‘хуянт-, янгина-, ярхир-’, мо. *quyangtu-* ‘хуянт-’) (HAMM, 10: 72r)
 ма. *falanggū da gala bethe-i sube nimere*, мо. *alay-a-yin uγ ɣar köl-ün sirbüsü ebedküi* ‘алганы уг гар хөлийн шөрмөс өвдөх’ (YT).

Одоо цагаар төгсгөх нөхцөл: ма. *-mbi*, мо. *-mui*² (IMPF.FINT)

Манж хэлэнд *-mbi* бүтээврийг хэрэглэж үйл үгийн одоо цагаар төгсгөх хэлбэрийг үүсгэнэ. Энэ бүтээврийн гарлыг тодорхойлсон хоёр таамаглал бий. Тэдгээрийн нэгийг И.И.Захаров, нөгөөг нь В.Банг дэвшүүлсэн. И.И.Захаров тодорхойлохдоо *-мби* хэлбэр нь *-мэ* болон би *-ээс* үүссэн гээд *-мэ* нь нөхцөл үйл үгийн одоо цагийн хэлбэр, харин би нь «байх» гэсэн үйл үг гээд аламби (аламэ би) ‘хэлмүй’ гэсэн жишээг авсан байна (Захаров, 1879: 173). Нөгөө нь В.Бангийн өнгөрсөн зууны сүүлээр дэвшүүлж, К.Менгесийн нэмэн баяжуулсан таамаглал юм. К.Менгес *-mbi* хэлбэрт хуучирсан нэр үндэс, эсвэл *-н* төгсгөлтэй үйлээс үүссэн нэр (*nomen praesentis*) байна гэж үзсэн. Тэрээр тэмдэглэхдээ «манж хэлний одоогийн *-н* -ээр төгссөн үндсэн дээр ‘байх, ахуй’ гэсэн би язгуур нэмсэн нь өөрөө ‘орших, байх’ гэсэн бие даасан үйл үгийн үндэс болж чаддаг (ала-н+би))» гэжээ (Суник, 1962: 321).

Манж хэлэнд *-mbi* бүтээврийг авсан үйл үг нь одоо цагийн утга илтгэдэг. Энэ тухай И.И.Захаров бичихдээ «Энэ хэлбэр нь манж хэлэнд аль ч цаг үед, одоо ч тэр түгээмэл хэрэглэгддэг, ялангуяа ярианы төгсгөлд, мөн аливаа зүйлийн талаар хэлэлцэхэд, түүнчлэн ахуй байдал, үйл хөдлөлийн учир шалтгаан, үг ярианы чадварыг харуулахад хэрэглэнэ» гэжээ (Захаров, 1879: 150).

Монгол хэлэн дэх *-mui*, *-müi* бүтээвэр нь үйлийн болох одоо ирээдүй цагийн утга илтгэдэг боловч үйлийн цагийн утга нь зарим тохиолдолд тун балархай болох байдал ажиглагддаг (Хасбаатар, 1990: 195). Энэ нөхцөлийн гарлыг эрдэмтэн Хасбаатар «*-mui*, *-müi* бол *-т* гэсэн тэмдэг үйл

үгийн хэлбэр дээр *-ui*, *-üi* гэсэн дагавар бүтээврийг залгаж бүтсэн нийлмэл дагавар гэдэг боловч энэхүү нь *-ui*, *-üi* - гийн тухай зарим эрдэмтэн үүнийг “дуурайж адилтгасан өгүүлэхүүний хэлбэр” гэж, зарим эрдэмтэн үүнийг “эгшгийн уртатгал” гэж, зарим эрдэмтэн нь харин үүний тухай юу ч хэлсэнгүй байна. Нөгөө талаар зарим судлагч харин дээрхтэй баахан адилгүй саналыг дурдаж энэхүү *-ui*, *-üi* бол “эртний монгол хэлний туслах үйл үг <буй>-аас ирэлтэй» гэж тодорхойлжээ (Хасбаатар, 1990: 195; 201-202).

Тольд ма. *-mbi*, мо. *-mui*² бүтээвэртэй үйл үгс элбэг байна. Өөрөөр хэлбэл, үйлийн нөхцөл авсан үйл үг бүрийг энэхүү нөхцөлөөр хэлбэржүүлэн тольд оруулжээ. Энэ бүтээвэр нь үйлийн эзний тооноос хамаараад олон тооны утга (жишээ 2) илтгэх бололцоотой нь доорх жишээнүүдээс илэрхий харагдаж байна.

- (1) ма. *wasihalambi*, мо. *mayajilamui* ‘маажилмуй’ (< ма. *wasihala-* ‘маажил-’, мо. *mayajila-* ‘маажил-’) (HAMM, 2: 69v-70r)
ма. *galai hitahün-i hederere*, мо. *yar-un qumusun-iyar maltaqui* ‘гарын хумсаар малтах’ (YT);
- (2) ма. *niyamniyambi* мо. *namnamui* ‘намнамуй’ (< ма. *niyamniya-* ‘намна-’, мо. *namna-* ‘намна-’) (HAMM, 4: 12v)
ма. *morilafi feksime gabtara*, мо. *morilaju dobtulun qarbuqui* ‘морилж довтлон харвах’ (YT);
- (3) ма. *gosimbi*, мо. *örüsiyemüi* ‘өршөөмүй’ (< ма. *gosi-* ‘өршөө-’, мо. *örüsiye-* ‘өршөө-’) (HAMM, 6: 55v-56r)
ма. *ahün deu ishunde jilame hairara*, мо. *aq-a degüü qarilčan nigülesün qayiralaqu* ‘ах дүү харилцан нигүүлсэн хайрлах’ (YT).

Бидний судалгааны хэрэглэгдэхүүн болгон авсан толь бичиг нь манж хэл дээр суурилсан. Тиймээс цагаар төгсгөх нөхцөл бүхий үйл үгсийг манж хэлний үүднээс тайлбарласан нь илэрхий юм. Энэ нь монгол орчуулгад нөлөөлж, зохиомол орчуулгыг бий болгосон байх магадлалтай. Гэсэн ч монгол хэлэнд таарч тохирох орчуулгыг олоход толийг зохиогчид хүчин чармайлт гаргасан нь анзаарагдаж байв. Ялангуяа төгсгөлийн өгүүлэхүүний үүрэг гүйцэтгэдэг ма. *-ha*³, *-ka*³, мо. *-ba*² нөхцөлийг авсан үйл үгсийн монгол тайлбарт тус нөхцөлийн утгыг мо. *-γsan*² нөхцөлөөр тайлбарласан нь анхаарал татаж, ма. *-ha*³, *-ka*³ нөхцөлийн утга монгол хэлэнд хоёр өөр нөхцөлөөр илрэх боломжтойг бататгаж байлаа. Манж хэлний *-habi*³, монгол хэлний *-jī*, *-čī* нөхцөлийг авсан үйл үгсийн тайлбарт хийсэн дүн шинжилгээгээр тус нөхцөлийн утгыг ихэвчлэн ма. *-ra*³, мо. *-qu*², цөөн тохиолдолд ма. *-ha*³, мо. *-γsan*² нөхцөлийг ашиглан илэрхийлжээ. Толь бичгийн хэлбэр болох *-mbi* нөхцөл нь тольд их хэмжээгээр орж, ердийн тохиолдолд үйлт нэрийн ма. *-ra*³, мо. *-qu*² бүтээврийн оролцоотой тайлбарлагджээ.

Товчилсон үгс

HAMM	<i>Han-i araha manju monggo gisun-i buleku bithe</i>
IMPF.FINT	одоо цагийн хэлбэр
PAST.FIN	өнгөрсөн цагийн хэлбэр
ҮТ	үгийн тайлбар
ма.	манж
мо.	монгол

On some verb final suffixes in Mongolian and Manchu Languages

The bilingual Manchu-Mongolian dictionary compiled during the reign of the emperor Kangxi (published in 1717) is an explanatory dictionary organized in subject order. Each verb as well as all other words in the dictionary is supplied by a commentary which explains its meaning. The paper deals with the Manchu and Mongolian verb determining Suffixes. Their commentaries explain the meanings sometimes different from the generally known ones.

Ном зүй

Мижиддорж, Го. (1976). Монгол, манж бичгийн хэлний харьцаа. Улаанбаатар: ШУА хэвлэл. [Mijiddorj, Go. (1976). Mongol, manj bichgiin khelnii haritsaa. Ulaanbaatar: ShUA kevlél.]

Монгол хэл судлал. (2022). *Монгол хэлний түүх. VI боть. Ер.ред. Д.Заяабаатар. Улаанбаатар. [Mongol kel sudlal. (2022). Mongol khelnii tuuk. VI boti. Yor.red. D. Zayabaatar. Ulaanbaatar.]*

Qasbayatur. (1990). *Mongyol manju kelen-ü sudulul. Köke qota.*

Kürelbayatur. (2021). *18 duyar jayun-u manju üsüg-iyer bičigdegsen mongyol kelen-ü material-un tiglel ba sudul-a. Öbür Mongyol-un yajar sinjilegen ayurqai-yin yarulta-yin keblekü üiledbüri.*


Захаров, И.И. (1879). *Грамматика маньчжурского языка. Санкт-Петербург: Издательство Типография Императорской Академии наук.*

Rita Kullmann., Tserenpil, D. (1996). *Mongolian Grammar. Ulaanbaatar: Jensco Ltd.*

Сунник, О.П. (1962). *Глагол в тунгусо-маньчжурских языках. Москва-Ленинград: Издательство АН СССР.*

高娃 (2005). *满语古语比较 究. 中央民族大学出版社. [Gao Wa (2005) Man yu gu yu bi jiao yan ji. Beijing.]*

Han-i araha manju monggo gisun-i buleku bithe // Qaγan-u bičigsen manju mongγul ügen-ü toli bičig. 1717. Оросын ШУА., Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн. Монгол номын хөмрөг. Шифр F 319.



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.